



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 356

Улаанбаатар хот

Хорооны 2014 оны 64 дүгээр тогтоолд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэргэшлийн шалгаруулалт явуулах, мэргэжилтэнд эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, 8 дугаар зүйлд дор дурьдсан агуулгатай 3.7.5 дахь заалт, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5 дахь заалт:

“3.7.5. Мэргэшлийн зөвлөлийн хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө хуралдаанд хэлэлцэх асуудлын жагсаалтыг Мэргэшлийн зөвлөлийн даргаар батлуулж, хэлэлцэх бичиг баримтын хамт гишүүдэд хүргүүлнэ.”

2/ 8 дугаар зүйлийн 5, 6, 7 дахь хэсгүүд:

“8.5. Мэргэшлийн зөвлөл нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон энэхүү журмын 8.1-д заасан түдгэлзүүлсэн зөрчил арилсан гэж үзвэл мэргэжилтний эрхийг сэргээнэ.

8.6. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтний эрхийг Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрээр хүчингүй болгосон бол уг шийдвэр гарсанаас хойш нэг жилийн хугацаанд түүнд дахин эрх олгохгүй.

8.7. Энэхүү журмын 8.5-д заасан хугацаа өнгөрсний дараа тухайн этгээд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтад хамрагдаж дахин эрх авч болно.”

2. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

“3.6. “Мэргэшлийн зөвлөлийн хуралдаан нь нийт гишүүдийн дийлэнх олонхи нь оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.”

3. Журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН